

# СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

## 6400 ШИРХЭГ ХҮЧИЛТӨРӨГЧИЙН БАЛЛОН НЬ ЭНЭ ЦАГ ҮЕД АЛТНААС ИЛҮҮ ҮНЭ ЦЭНТЭЙ

“Глобал Ацителин” ХХК “Дезерет” олон улсын энэрлийн байгууллагатай хамтран Цэргийн төв эмнэлэгт 100 сая төгрөгийн үнэ бүхий хүчилтөрөгчийн хийг хандивлалаа. Батламжийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Цэргийн төв эмнэлгийн эмнэл зүй эрхэлсэн орлогч, хурандаа Р.Баянмөнх нар гардан авлаа. Батламжийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг “Манай Цэргийн төв эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд улс оронд коронавирус алдагдсан цаг үеэс ХӨСҮТ-тэй нэгэн адил энэ аюулт өвчний эсрэг сөрөн тэмцэж, олон мянган хүний амь насыг аюулт өвчнөөс авраад байна. Та бүхний хандивлаж буй хүчилтөрөгч цаашдаа олон хүний алтан амийг аврахад ус агаар мэт хэрэг болно” гэсэн юм.

Цэргийн төв эмнэлгийн эмнэл зүй эрхэлсэн орлогч, хурандаа Р.Баянмөнх “Бид “COVID-19” дэгдсэнээс хойш 2300 гаруй хүнийг аюулт өвчнөөс эдгээгээд байна. Одоогийн байдлаар халдвар авсан хүмүүсийн тоо буурах хандлагатай байгаа ч хэвтэн эмчлүүлж буй хүмүүс доторх хүндэрсэн өвчтөнүүдийн тоо улам нэмэгдэх хандлагатай байна. Тэгэхээр бидэнд хандивласан 100 сая төгрөгийн үнэ бүхий 6400 ширхэг хүчилтөрөгчийн баллон нь энэ цаг үед бидэнд алтнаас илүү үнэ цэнтэй бэлэг боллоо” гэв. “Глобал Ацителин” ХХК-ийн захирал Ж.Ганбат “Манай компани нийгмийн хариуцлагынхаа хүрээнд өмнөх жил ХӨСҮТ-д жилийн хэрэглээ 3300 баллон хүчилтөрөгч бэлэглэж байсан. Гэтэл одоо цагт энэ нь сарын хэрэглээнд ч хүрэхгүй байна. Иймд бид энэ удаа 6400 ширхэг баллоныг хандивлахаар шийдсэн” гэлээ.



ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 16	🌧️ 1
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	🌧️ 23
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	🌧️ 12

ВАЛҮТЫН ХАНШ		
ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.845.00	2.856.00
EUR 🇪🇺	3.431.00	3.491.00
CNY 🇨🇳	441.00	444.40
RUB 🇷🇺	37.90	39.60
JPY 🇯🇵	25.75	26.24
KRW 🇰🇷	2.44	2.57

### ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 06  
2021.05.18.  
/МЯГМАР ГАРАГ/

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН  
МОГОЙ САРЫН ТАВАН ШАР  
УЛААН БАР ӨДӨР**

Үс засуулбал:  
Өнгө зүс сайжирна.  
Наран ургах, шингэх:  
05.10-20.27  
Барилдлага:  
Үхэх  
Шүтэн барилдлага:  
Төрөхүй  
Суудал:  
Төмөр.

Аргын тооллын 5 сарын 18, Ангараг гараг. Билгийн тооллын 6, Үнэг одтой, улаан бар өдөр. Өдрийн наран 5 цаг 10 минутад мандан, 20 цаг 27 минутад жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал адеуус муулах, сүм дуганыг сэргээх, амлуулах, өглөгийн түллээ хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, андаг тангараг, гэрээ, хэлцээ буцаахад сайн. Гөлөг тэжээх, золиг гаргах, бомбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одоосод баруун урагш мөргөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өнгө зүс сайжирна.

## МАРШИЙН АВАРГУУД ТОДОРЛОО

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Маршутсгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд амжилттай явагдаж өндөрлөлөө.

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаа энэхүү тэмцээн нь 2007 оноос хойш уламжлал болгон явагдаж ирсэн бөгөөд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг нэмэгдүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийг дээшлүүлдэг онцлогтой. Энэ удаагийн тэмцээнд цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын баг тамирчид оролцож чадаагүй ч тасалдуулахгүйгээр Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалуудын хэмжээнд зохион байгуулагдсан юм. Цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг сорих энэ тэмцээн оролцогчдын тоог салаанаас рот хүртэлх бүрэлдэхүүнтэй болгон нэмэгдүүлж, тэмцээний журамд эзлэгдсэн объектыг чөлөөлөх, гранат шидэх, буудлагын шинэ төхөөрөмжүүд ашиглах зэрэг өөрчлөлтүүдийг оруулсан юм.

Энэ жилийн Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээний Ротын нэгдүгээр байрт Тусгай хүчний цэргийн командлал, 2 дугаар байрт Хуурай замын цэргийн командлал, Байнгын бүрэлдэхүүний салааны 1 дүгээр байрт Тусгай хүчний цэргийн командлал, 2 дугаар байрт Хуурай замын цэргийн командлал, Хугацаат цэргүүдийн салааны 1 дүгээр байрт Зэвсэгт хүчний 032 дугаар анги, 2 дугаар байрт Зэвсэгт хүчний 119 дүгээр анги, 3 дугаар байрт Зэвсэгт хүчний 167 анги тус тус шалгарсан бол Эмэгтэй тасгийн 1 дүгээр байрт ЗХЖШ-ын тасаг, 2 дугаар байрт Тусгай хүчний цэргийн командлал тус тус шалгарчээ.



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
49.175	41.844	214/12
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ		
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
2316 (30)	229	2056

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Төхиолдол	Нийт: 162,177,376
Эдгэрсэн	Нийт: 136,589,576
Нас барсан	Нийт: 3,364,178

### ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	10,308
НИЙТ	2,441,556
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	4,764
НИЙТ	2,827,220
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	1,109
НИЙТ	404,508
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	754
НИЙТ	76,049

2021.05.16 11:00 ЦАГИЙН БАЙДАЛ

ЦАХИМ ШУУДАНД

# “ХҮНДЭТ ТЭМДЭГ” ЭНГЭРТ НЬ ГЯЛАЛЗЛАА

Батлан хамгаалах яамны “Ахмадын хороо”-ны үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг нь үнэлж ЗХЖШ-ын Хэвлэл мэдээллийн албаны дарга, хэвлэлийн төлөөлөгч, хурандаа Б.Отгонбаярыг “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа. “Ахмадын хороо”-ны дарга, чөлөөнд байгаа хошууч генерал Д.Магсаржав “Бидний дэвшүүлсэн зорилго, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулахад идэвх зүтгэл гаргаж “Соёмбо” сонин, “Дуулга” студийн сэтгүүлч, уран бүтээлчидтэй хамтран, хамт олноо манлайлан ажиллаж байсанд талархал илэрхийлье. Цаашид ч бидний үйл ажиллагааг идэвхтэй дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хойшилсоор энэхүү шагналыг энэ өдөр гардуулж байгаа ч үнэ цэнээ алдаж, хуучраагүй” гэж онцлоод “Хүндэт тэмдэг”-ийг хурандаа Б.Отгонбаярын энгэрт нь зүүж өгөв. Үүний дараа хурандаа Б.Отгонбаяр “Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залууст цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэхэд Батлан хамгаалах яамны “Ахмадын хороо”-ны удирдлага, гишүүдийн үүрэг оролцоо өндөр байсаар ирсэн.



Энэ ч утгаараа ахмадуудынхаа санал, зөвлөмжийг сонсож, цаг ямагт тэднээсээ суралцдаг. Энэ “Хүндэт тэмдэг”-ээр энгэрээ доолсон явдлыг цаашид улам ихийг хийж бүтээгээрэй

гэсэн үүрэг даалгавар, хариуцлага гэж ойлгож байна. Батлан хамгаалах яамны “Ахмадын хороо”-ны хамт олонд ажлын өндөр амжилт, аз жаргалын дээдийг хүсэн ерөөе” гэв.

## АХМАД ХОЛБООЧНЫ 100 НАСНЫ ОЙ ТОХИОЛОО

Зэвсэгт хүчний 013 дугаар анги

1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин, чөлөөнд байгаа бэлтгэл дэд хурандаа

Ахмад холбоочин дайчин, чөлөөнд байгаа бэлтгэл дэд хурандаа Т.Бат-Очир гуайн 100 насны өдрийг тохиолдуулан ЗХЖШ-ын ХМТХ-ийн дарга, хурандаа М.Золзаяа Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль,



Төмөрийн Бат-Очир нь өдгөө 100 насны ойгоо тэмдэглэж байна. Тэрээр 1921 онд Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын нутагт мэндэлсэн бөгөөд Зэвсэгт хүчний 100 жил тохиож буй энэ цаг хугацаанд эрүүл энх, урт удаан наслахын зэрэгцээ сүүлийн жилүүдэд шүлэг, яруу найргийг сонирхож “Есөн манжлагат цагаан туг”, “Жанжин тугийн намираа”, “Цэргийн холбоо” зэрэг олон дууны шүлгүүдийг бичсэн нэгэн юм.

ахмадын зөвлөлийн дарга, бэлтгэл хошууч Ё.Эрдэнэбилэг алд цэнхэр хадаг, идээний дээж, мөнгөн аяга гадуулсан бол Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн захирагч хурандаа Ч.Эрдэнэболд Хүндэт өргөмжлөл, дурсгалын сэлмийг гардуулан өгч хүндэтгэл үзүүллээ. Бэлтгэл дэд хурандаа Т.Бат-Очир баярлаж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ олон сайхан дурсамж түүхийг өгүүллээ.

## АНХНЫ ЖИШИГ НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ АНГИ БОЛНО



Зэвсэгт хүчний 015 дугаар анги

Тус анги түүхт 100 жилийн ойгоо угтан хамгийн анхны жишиг ногоон байгууламж бүхий анги болох зорилт тавин бүтээн байгуулалтын ажлуудаа шат дараатай хийж эхлээд байна. Тухайлбал, дөрвөн га талбайд зүлэгжүүлэлт хийж, 5000 орчим шилмүүст мод тариад байгаа бөгөөд тус ажилтай Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өнгөрсөн амралтын өдрүүдээр танилцсан юм.

Тэрээр энэ үеэр “Цаашид хугацаат цэрэгтэй ангиудыг шат дараалалтайгаар жишиг ногоон байгууламж бүхий анги болгохоор зорьж байна. Алба хааж байгаа анги нь эко орчныг бий болгосноор хугацаат цэргүүдийн хувьд ч тайван сайхан мэдрэмж төрөхөөс гадна, тарьсан мод бүрээ өөрсдөө арчилж, ургуулах нь нэг талаараа ногоон хөгжилд оруулж буй хувь нэмэр юм. Энэхүү ажил нь зүгээр нэг төсөл биш. Эхлүүлж санаачилж байгаа нь чухал хэдий ч цаашид арчилж авч явах нь бүр чухал” гэгийг онцлоод 100 жилийн ойгоо өнгөтэй, үзэмжтэй угтаж буй 015 дугаар ангийн бие бүрэлдэхүүнд амжилт хүслээ.

## ЦӨЛЖИЛТИЙН ЭСРЭГ ХАМТДАА



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Тус ангийн 103 дугаар тусгай ротын хамт олон бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан “Хуурайшилт, цөлжилтийн эсрэг хамтдаа” уриан дор мод тарьж, нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мөн Баян-Хонгор аймгийн Баянлиг сумын төв цэцэрлэгт хүрээлэнд 200 гаруй улиас модыг суулгаж, газрыг хөрсийг нөхөн сэргээх, зүлэгжүүлэх ажлыг хийгээд байгаа

байгаа офицер, ахлагч, энгийн ажилчин алба хаагч болон чөлөөнд гарсан ахмад дайчдад Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Цэргийн гавьяаны одон, Цэргийн хүндэт медаль, Энхийн төлөө, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль гардуулах ёслолын ажиллагааг 2021 оны 05 дугаар сарын 10-аас 14-ны өдрүүдэд “Covid-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх хорио цээрийн дэглэмийг чанд сахиулж цэргийн алба хаагчдыг аль болох бөөгнөрүүлэхгүйгээр зохион

## РСР ШИНЖИЛГЭЭНИЙ СУУРИН ГУРВАН ЦЭГИЙН БАЙРШИЛ ӨӨРЧЛӨГДЛӨӨ

Нийслэлийн төвийн зургаан дүүрэгт суурин гурав, явуулын гурван PCR шинжилгээний цэг ажиллаж байна. Дээрх цэгүүдэд хөдөө, орон нутаг зайлшгүй явах шаардлагатай, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, мөн оршуулгын үйл ажиллагаанд оролцох иргэд цаг авалгүй очин, шинжилгээнд хамрагдах боломжтой.

Шинжилгээний цэгийн байршлууд өөрчлөгдсөн бөгөөд дараах цэгүүдэд авч байна.

- 1.Баянгол дүүрэг-96 дугаар сургууль /Хуучин 13-р сургуулийн шинжилгээний цэг/
- 2.Сүхбаатар дүүрэг-143 дугаар цэцэрлэг /Хуучин 31 дүгээр сургуулийн шинжилгээний цэг/
- 3.Чингэлтэй дүүрэг-74 дүгээр цэцэрлэг /Хуучин 50 дугаар сургуулийн шинжилгээний цэг/
- 4.Баянзүрх дүүрэг- “Тэнгэр” худалдааны төвийн гадна талбай
- 5.Сонгинохайрхан дүүрэг-Таван шарын төмөр замын гармын ард байрлах “Номин” агуулах



худалдааны гадна талбай  
6.Хан-Уул дүүрэг- Буянт-Ухаа спорт цогцолборын гадна талбай.  
Дээрх цэгүүд ажлын өдрүүдэд 09:00-12:00 цагийн хооронд ажиллах бөгөөд амралтын өдрүүдэд гурав, гурваараа ээлжлэн ажиллана.  
Үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний газар, байгууллагууд

нь вакцины бүрэн тунд хамраагдаад 14 хоносон гэрчилгээтэй болон өвчлөөд эдгэсэн тухайн эмчийн магадлагаатай хүн ажиллуулах бөгөөд мөн дээрх бичиг баримтыг үндэслэж иргэдэд үйлчилнэ.

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ



бөгөөд орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагуудыг зүлэг, мод тарихыг уриаллаа.

Түүнчлэн Зэвсэгт хүчинд 10-аас дээш жил ажиллаж, алба хааж

байгуулж ажиллаа. Ангийн удирдлага одон медалиар шагнагдсан бие бүрэлдэхүүнд болон ахмад дайчдад хандаж ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх сайн сайхныг хүсэн ерөөлөө.

Ахмад Ц.ЦЭВЭГДОРЖ